



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000. Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.08.13 № 549
танай _____-ны № _____-т

ДОРНОД АЙМГИЙН ГУРВАНЗАГАЛ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ДОРНОД АЙМГИЙН
МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛТ НАМЫН
ТҮМТИЙН ДАРГА Ж.ЭНХЖАРГАЛ ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Хурлын сонгуульд оролцох Гурванзагал сумын Монгол ардын хувьсгалт намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Гурванзагал сумын Монгол ардын хувьсгалт нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Гурванзагал сумын Монгол ардын хувьсгалт намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817 - 8: 2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050", холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

"Гурванзагал сумын Монгол ардын хувьсгалт нам"-ын сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.


"Гурванзагал сумын Монгол ардын хувьсгалт нам"-ын мөрийн хөтөлбөр /.... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Дорнод аймгийн сонгуулийн хороонд

Хавсралт хуудастай.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ



**МАХН-ЫН ГУРВАНЗАГАЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН
ХУРЛЫН 2020 ОНЫ СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

ИРГЭДЭЭР ОВОГЛОСОН, ИРГЭДИЙН ТӨЛӨӨ ХӨТӨЛБӨР

Зорилт

МАХН нь орон нутгийн иргэдийнхээ ашиг, сонирхлыг удирдлага болгож, ардчилал, эрх чөлөөний үзэл санаанд тулгуурлан экологийн чиг баримжаатай нийгэм-эдийн засгийн тогтвортой хөгжлийг бий болгон эрүүл аюулгүй орчинд амьдрах боломжийг бүрдүүлэхэд оршино. Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд:

- Монгол хүн бүр эрүүл аюулгүй хотод амьдрах эрхийг дээдлэж Өрх бүрт орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлэнэ.
- Эхний ээлжинд эмзэг бүлгийн өрхийн нэг гишүүнийг ажлын байраар хангах бодлого баримтална.
- Иргэд орчин үеийн эмчилгээ, оношлогооны өндөр өртөгтэй, нарийн төвөгтэй оношлогоо эмчилгээ хийлгэх тохиолдолд зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас олгох үйл ажиллагааг өргөжүүлнэ.
- Зээлийн хүүг бууруулж бизнесийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтыг дэмжинэ.

Орон нутгийн төр засгийн байгууллага, албан тушаалтнууд хариуцлага хүлээдэггүй өнөөгийн гаж тогтолцоог халж Монгол хүнийг хамгаалдаг иргэндээ ээлтэй нутгийн захиргааны шинэ тогтолцоонд шилжинэ.


МАХН нь эх оронч үзэлтэй мянга мянган шударга иргэдийн ирүүлсэн экологи, улс төр, соёл, эдийн засаг болон нийгмийн хөгжлийн өнөөгийн дүр төрхийг дүгнэсэн, улс эх орныхоо хөгжлийг хурдасгах өргөн хүрээтэй шийдвэртэй алхмуудыг санал болгож байна.

Хөтөлбөрийн хүрээнд ИРГЭН -НОГООН СОЁЛ ИРГЭНШИЛ дэд хэсэгт экологи, улс төр, соёл, эдийн засаг болон нийгмийн асуудлаас бүрдсэн хоорондоо харилцан хамааралтай хүн төвтэй хөгжлийн бодлогыг бий болгоно.

НЭГ. ИРГЭН ТАНЫ АМЬДРАЛД

Иргэн та нас, хүйс, шашин шүтлэг, намын харъяалал, угсаа гарал, оршин амьдарч буй газар, нийгмийн байр сууриас үл хамааран хүн бүр эрхэм чанараа мэдрэн, айх аюулгүй, эрх чөлөөтэй Эрүүл орчинд амьдран, сурч боловсрох эрхтэй.

- Жирэмсэн эмэгтэйчүүд 3-5 насны хүүхэдтэй ажилчин, ажилтныг ажиллуулж буй аж ахуйн нэгжүүдийг татварын бодлогоор дэмжих,
- 0-5 настай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ,



- Иргэд орчин үеийн эмчилгээ, оношлогооны өндөр өртөгтэй, нарийн төвөгтэй оношлогоо эмчилгээ хийлгэх тохиолдолд зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас олгох үйл ажиллагааг өргөжүүлнэ.
- Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, дэмжих зорилгоор иргэд биеийн тамирыг хүн бүрийн амьдралын эрүүл дадал нөхцөл бололцоог нээхийн зэрэгцээ “ЭРҮҮЛ ЗӨВ АМЬДРАЛ”, “ЗӨВ ХҮНС” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

ХОЁР. ӨРХ, ГЭР БҮЛИЙН АМЬДРАЛД:

Монгол Улсын тулгуур баялаг нь “Монгол өрх” мөн тул аймаг орон нутагт амьдарч буй өрх гэр, залуу гэр бүл, иргэдийг тохилог орон сууцанд амьдрах бодлогыг боловсруулан, өрх бүрийг орон сууцаар хангах зорилт тавьж ажиллана.

- Сумдад хувийн орон сууц барих бодлогыг дэмжин ажиллана.

ГУРАВ. СУМЫН ХҮРЭЭНД:

- Ахмадуудыг төр засгийн байгууллагад сайн дурын зөвлөхөөр авч ажилуулж, ахмад мэргэжилтнүүдийг зохих урамшуулалтайгаар ажиллуулсан ААН-үүдийг татварын тогтолцоогоор урамшуулах
- Иргэд амьдрах таатай эрүүл цэвэр, ногоон технологи бүхий хаягдалгүй орчинг иргэдийн оролцоотойгоор бүрдүүлэх,
- Сумын төвүүдэд хөдөө аж ахуйн бүтээгдхүүн, малын гаралтай нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг бодлогоор дэмжиж хөгжүүлэх эрх зүйн өөрчлөлтийг хийх,
- Хүнсний аюулгүй байдлыг ханган, малын гаралтай эцсийн бүтээгдэхүүнийг экспортлон малчдын орлогыг төрөлжүүлэн нэмэгдүүлэх зорилгоор малыг эрүүлжүүлэх аяныг өрнүүлэх,
- Сумдад “Цагаан алт” болох ноосыг боловсруулах, жижиг дунд үйлдвэрийг дэмжих,
- Алслагдсан бэлчээрийг худаг усаар хангахад дэмжлэг үзүүлэх,
- Хүүхдийн цэцэрлэг, сургуулийн хүрэлцээг нэмэгдүүлэн хүүхдэд ээлтэй ногоон орчин бүрдүүлэх бодлогыг дэмжих
- “Эрүүл зөв амьдрал”, “Зөв хүнс” хөтөлбөрийг нэн тэргүүнд цэцэрлэг, сургууль, олон нийтийн үйлчилгээний газруудад хэрэгжүүлэх,

ДОРНОД АЙМГИЙН
МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛТ НАМ

